

С.Янжинсүрэн

Шашин судлалын тэнхимийн
багш, доктор, дэд профессор

**Заваа дамдин гавжийн зарим шастир дахь
төв үзлийн гүн ухааны асуудлаас**

Түлхүүр үг: Төв үзэл, шүтэн барилдлага.

ЭШӨ-ийн товч утга: Заваа гавжийн гүн ухааны шастарууд дотор төв үзлийн гүн ухааны зохиолууд голлох байр суурийг эзлэнэ. Тэрээр үнэхээр эс бүтэхүй хийгээд шүтэн барилдлагын зарчмыг төв үзлийн гүн ухааны тулгуур зарчмууд мөн гэж үзэж хоосон чанарыг илэрхийлэх гол арга зүйгээ болгож байв.

XIX зууны сүүлч -XX зууны эхэн үеийн монгол шашин хийгээд нийгэм, соёлын томоохон зүтгэлтэн, соён гэгээрүүлэгчдийн нэг нь олноо Заваа хэмээн алдаршсан Лувсандаян буюу Шагдарын Дамдин гавж /1867-1937/ мөн билээ. Монголын түүхийг бичилцсэн, өнөөгийн ШУА-н суурь болсон Судар Бичгийн Хүрээлэнгийн анхны гишүүдийн нэг асан түүний нэрийн өмнө ёс мэт явдаг “Заваа” /rtsha ba/ гэдэг тодотгол нь эш үндэс гэсэн утга бүхий төвд үг бөгөөд буддын гүн ухааны таван үндэс болох чойрын таван ботийг нэвтэрхий мэдсэний тул ийнхүү алдаршсан болой. Тиймээс ч түүнийг Шагдарын гэхээсээ Заваа гэх нь илүүтэй олны танил болсон байна. Тэрээр буддын дотоод ухаан гэх гүн ухааны чиглэлээр 20 гаруй шастар ном туурвисан бөгөөд тэдгээрийн дотор төв үзлийн чиглэлээр бичсэн зохиол бүтээл олон байгаа юм. Үүнд:

1. “Төв үзлийн ерөнхий утгын зүүлт тайлбар, Гүн утгыг машид тодруулагч зул”¹
2. “Төв үзлийн шастар Нягтад тээрэмдэгчийн тайлбар, Ухаарахуй ёст алтан хүрдэн”²
3. “Вишнү тэргүүтэн гагц бүхнийг бүтээгч хэмээхүйг арилган үйлдэгч номлол, Зуун буруу үзлийг буцаагч ганц эм”³
4. “Нигүүлсэхүй сэтгэлийн дуулал, Зуун найман шүлэгт болор эрдэнийн эрхи”⁴ тус тус болно.

¹ dBu ma'l spyl don gol mchan 'grel zab don rab gsai sgrom me Сүмбүм Nga боть 141-456 дахь талд

² dBu ma'l bstan bcos zhib mo nam thag gi 'grel pa rigs thsul gser 'khor lo, Сүмбүм, мөн боть, 471-488 дахь талд

³ dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l nam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, мөн боть, 457-470 дахь талд

⁴ sNying rje chen po la pstod pa'l tshigs bcad bgya rtsa brgyad pa rin chen shel pgreng, Сүмбүм, Ка боть, 103-116 дахь талд

Заваа Дамдин гавжийн гүн ухааны зохиолууд ихэвчлэн тайлбар зохиол байх юм. Ингэснээрээ Дамдин үгвэрийн зохиол бүтээлийн үнэ цэнэ буурч байгаа бус харин ч тэрээр эртний энэтхэг, төвдийн их мэргэдийн зохиол бүтээлүүдтэй танилцаж түүний утга санааг тайлбарлаж үзэл бодол зөрсөн хэсэгтээ эртний ном судраас шүн татаж залруулан өөрийн үзэл санааг илэрхийлж, улам баяжуулж төвд хэлээр туурвисан нь түүний зохиол бүтээлийн нэг үнэ цэнэтэй тал болно. Тийм бүтээлийн нэг нь эртний энэтхэгийн гүн ухаантан Нагаржунагийн “Эрхэт үйлдэгч мөнийг арилгахуй хийгээд Вишнү үйлдэгч ганцыг арилган оршив”⁵ хэмээх шастарын тайлбар “Вишнү тэргүүтэн гагц бүхнийг бүтээгч хэмээхүйг арилган үйлдэгч номлол, Зуун буруу үзлийг буцаагч ганц эм” хэмээгч шастар болно. Тус зохиолыг 1930-1931 засварт бичиж дуусгасан. Тайлбарын эх сурвалж болсон Нагаржунагийн бүхнийг бүтээгчийг төв үзлийн үүднээс няцаан бичсэн бүтээл Монгол Данжуурын 221 дүгээр ботийн 623 дээд-626 дээд талд санскрит, монгол эхээрээ буй бөгөөд бусад барын данжууруудад хадгалагдаж буй.

Нагаржунагийн эл зохиолд хийсэн тайлбар лав Данжуурт нэг ч байхгүйг хэлэх хэрэгтэй монгол сэтгэгчдийн бүтээлд ч ийм тайлбар өөр тааралдахгүй байгаа юм. Тус бүтээлийн судалгаа хийгдсэнээс Frederick William Thomas, George Chemparathy, Ф.Щербатской⁶ нарын судалгааг дурдъя.

Нагаржунагийн эл шастар хэмжээний хувьд харьцангуй бага, харин Заваа Дамдин гавж судрын 7 хуудсаар тайлбар болгон бичжээ. Нагаржуна шастараа дотоод хэсгүүдэд задалж хуваалгүй бичсэн бол Дамдин гавж нэрийн утга, гол утга, эцсийн утга гэсэн үндсэн гурван хэсэг, хэд хэдэн дэд хэсэгт хуваан агуулгыг гаргаснаараа бичлэгийн хувьд онцлог болно. Тэрээр “...Хутагт Лүдэв шүтэн гарч цацлаас хагацсан утгыг гийгүүлэн зохиосон сайн номлол, рашаан далайн зүрхэн мэт гол өчүүхэн нэгнийг Данжуурын дотроос олоод үйлсээ арвижуулахыг хүссэн санаагаар үгийн утгыг бүдүүн тоймоор өөрийн оюуны хэмжээ чинээгээр тайлбарлан үйлдсэн”⁷ байна.

⁵ dBang phyug byed pa po nyid sel ba dang phyab 'jug byed pa po gcig nyid sel bar byed pa zhes bya ba'

⁶ Frederick William Thomas. Notes from the Tanjur. Isvarakarttrvanirakti-visnorekakartrvanirakarana. 1903. JRAS. Ф.Щербатской. Abuddhist philosopher on Monotheism. Tr. By Harish C. Gupta Indian Studies Past and Present. Repr. N.C Gupta, ed., Papers of Theodore Scherbatsky, Calcuta, 1969. Pp., 10-16; George Chemparathy. Visnorekakartrvanirakarana . 1968 in "Two Early Buddhist Refutations of the Existence of Isvara as the Creator of the universe" Frauwallner Festschrift, pp. 85-100, at pp. 97-99

⁷ dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l nam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, Nga боть, 457 дахь талд

Буддын сургаалын нэгэн тэмдэглүүштэй шинж нь гэвэл, тэрбээр Энэтхэг орноо ноёлж агсан бярманы шашны эсрэг гарч ирж, бүгдийг бүтээн чадагч бурхан хийгээд ид шидтэн байхыг няцааж байсан”⁸ бөгөөд “... дундад үзэлтнүүд бүгдийг үүсгэн бүтээн чадагч бурхан тэнгэр байдгийг үгүйсгэж, шашны бүх ойлголтыг аливаа бүхний нэгэн адил хоосон чанарт, харьцангуй утгат”⁹ хэмээн тайлбарладаг. Түүнлэн Нагаржуна “Эрхэт үйлдэгч мөнхүү буй хэмээхүй үүнээ машид шинжлэгдэхүй. Аль үйлдсэн тэр үйлдэгч хийгээд аль үйл үйлдсэн тэр үйлдэгчийн нэр дор болох бөгөөс үүнээ ч та нугуудаа өгүүллрүүн. Хэрвээ энэ бүтсэн нэгийг үйлдвээс, түүнээ бүтсэн нэгийг үйлдвүү. Түүнээ бүтсэн нь хоромхоноо үл үйлдюү. Бүтээгч үгүйн тул болой. Үлгэрлэвээс бодгаль бүтэхүй дор ч шалтгааны үйлдвэр үйлдэгчид үгүй бөлгөө. Урьд бүтсэний тул болой. Хэрвээ эс бүтсэн бөгөөс элсэн дор гүнжидийн тос эс бүтсэн хийгээд яст мэлхийн үс тэргүүтэн эс бүтсэн тул тэрхүү үйлдвээс жич үүнээ үйлдэгч бээр үл бүтюү. Хэрхэж хэмээвээс бод эс бүтсэний тул болой. Хэрвээ бүтсэн хийгээд эс бүтвээс эл тэр ч зохисгүй бөлгөө. Эсрэг тэсрэг харшлахын тул болой. Аль бүтсэн тэр бүтсэн хийгээд аль эс бүтсэн тэрхүү эс бүтсэн бөлгөө”¹⁰ хэмээснээс Нагаржуна гэгээний зохиолын агуулга тодорхой буй. Бүхнийг бүтээгч буй гэхүл бүтсэнийг бүтээснийг бүтээгч гэх үү, эс бүтсэнийг бүтээгчийг бүтээгч гэх үү, бүтсэн эс бүтсэнийг бүтээгчийг бүтээгч гэх үү хэмээн сөргүүлэн тавьж бүтсэнийг бүтээсэн гэвэл урьд нэгэнт бүтсэн учир түүнд бүтээгч гэж юун нэгэн байх, эс бүтсэнийг бүтээсэн гэхүл элсэнд гүнжидийн¹¹ тос, яст мэлхийд үс тэргүүтэн бүтээгүй зүйлс олон буй; тэр бүгдийг хэрхэн бүтээж чадах юунаас ч юуг ч бүтээн чадах тийм хүчин төгөлдөр эрхэт тэнгэр гэж хаана ч үгүй хэмээн дүгнэсэн байна. Яг түүнчлэнгээр бүтсэн, эс бүтсэнийг бүтээсэн гэж нэгэн зэрэг байж үл болох хэмээн өгөөдөж хэлсэн нь бүхнийг бүтээгчийг тал бүрээр үгүйсгэн няцааж эсрэг өгүүлэгчийг хаасан хэрэг болой. Харин Дамдин гавж “...Ванчүг тэргүүтэн цор ганц үйлдэгчийг арилган үйлдэгч хэмээн нэр зүүсэн нь ханьцашгүй их Жову гэгээн бээр шастар бүгдэд өгүүлэгдэхүүн утгын үүднээс нэр өгөх Энэтхэгийн мэргэдийн тогтсон ёсонд зарлигласан бөгөөд гол үүнээ хувь төгс номхотгох дор нирваны эндүүрэл үгүй мөр, хоосон чанарын үзлийг үзүүлэхүйийн тулд түүний халил газрын гол эрхэн нь өөрийн эрхшээсэн зай бүхий Ванчүг тэргүүтэн

⁸ Г.Лувсанцэрэн. Нагаржунагийн философийн үзэл, УБ., 1981, 19 дэх талд

⁹ Мөн тэнд, 33 дахь талд

¹⁰ Монгол Данжуур, 221 дүгээр боть, 623 доод-624 дээд талд

¹¹ Халуун оронд ургадаг нэг наст ургамлын нэр. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966, 166 дахь талд

орчлонг үйлдэгч цорын ганц дор үзэх буруу үзлүүдийг үнэхээр ухаанаар залхаан цээрлүүлээд арилган үйлдэхийн тул”¹² хэмээсэн эхлэлийн энэ үгнээс эл тайлбар зохиолын нь агуулга зорилт тодорхой болж байна. Тэрээр “...Ер эгэлүүд бээр шалтгаанаас үр төрөх хэмээсэн томъёоноос бус түүний утгыг онон шинжилж үл үйлдэх, тэрсүүд нар шалтгаан хэмээхийн томъёо зүүсний нэрийдсэн утгыг ухаанаар эрснээс муу гол хийгээд хуурмаг ухаан аль зохистойн үүднээс мөнхөд өгүүлэгч бээр Ванчүг, Вишнү тэргүүтэн өөрийн эрхэт эдтэд бүтсэн шалтгаан нэгнийг олсноо эрэмшээд, чухам сав шимийг үйлдэгч ганцад өгүүлэх болой. Тасархайд өгүүлэгчид бээр түүний бэлэгдлийн суурь юуныг ч илт эс үзсэнээр сав, шим бүгд шалтгаангүйгээр төрнө хэмээмүй. Таалах ёсон энэ нь ертөнцийн томъёо лугаа харшлах, түүнийг илт шалгадгаар ч ялгах ба бусад тэрсүүдүүд ч хязгаар тасархай тогтсон таалалд тооцох хийгээд мөнхөд өгүүлэхийн тааллыг хаахын сацуу тул энэ гол дор хориглохыг бодитой эс зохиосон мэт болой”¹³ хэмээн гадаад тогтсон таалалтнуудыг тасархайд өгүүлэгч, мөнхөд өгүүлэгч хэмээн хоёр ангилж, үүнээс тасархайд өгүүлэгч нь сав, шим бүгд шалтгаангүйгээр төрдөг гэснээрээ ертөнцийн томъёо лугаа харшилдаг, илт шалгадгаар ч няцаагддаг хэмээн харин нөгөө мөнхөд өгүүлэгчийг л няцаах нь гол гэж онцолж үзсэн байна. Улмаар тэд бүхнийг мөнх гэдэг нь угтаа юунаас ч үл хамааран бүхнийг бүтээн үйлдэгч эрхэт ганц буй хэмээх үзлээс нэг гол үндэслэгээ болгох тул эл мөнхийн хязгаарыг няцаан хаахын тулд тэрхүү эрхэт ганцыг шүүмжлэн хорих нь чухал гэсэн болно.

Заваа Дамдин гавж, хэрвээ өөрийн эрхтэн эдээс бүтсэн цорын ганц шалтгааныг Ванчүг гэвэл:

-Үр, шалтгаан, нөхцөлд дулдуйдаж илт бүтсэн нэгнийг төрүүлж чадах уу? Чадна гэвэл үр өөрийн шалтгаанаас бүтсэнүүд нь түр нэгнээ Ванчүгийг төрүүлэн үйлдсэн бус. Нэгэнт бүтсэн бодит юм алинд ч эргэж бас бүтээн үйлдэх ёс үгүй. Үлгэрлэвээс эцэг эхээс мэндэлсэн бодгаль эргэж бусдууд түүний эцэг эхийг үйлдсэнээс төрүүлэн үйлдэгч болох ёс үгүй бөгөөд тэр бодгаль нь урд өөрийн эцэг, эхээс бие бүтсэн тул болой. Хэрэв биднийг Ванчүг л бүтээсэн юм бол бидэнд эцэг, эх хаанаас заяасан байх вэ? Гэж бүхнийг бүтээгчээс бид бүтээгүй юм, бид шалтгаан үрийн холбоонд оршиж, эцэг эхийн хүчинд дулдуйдан бүтсэн юм хэмээн өгүүлж байна.

¹² dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l nam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, Nga боть, 458-459 дэх талд

¹³ Мөн боть 460 дахь талд

-Шалтгаан нөхцөл алинаас ч эс бүтсэн нэгнийг төрүүлэн үйлдэгчид тооцох уу? Тооцогдоно гэвэл эс бүтсэнийг төрүүлэн үйлдэнэ хэмээвээс элснээс гүнжидийн тос урьд эс бүтсэн ба яст мэлхийн үс тэргүүтэн ч урд эс бүтсэний тул тэдгээрийг Ванчүг шинээр бүтээн үйлдэх болбол энэ ертөнцөд урьд эл гадны дотны төрүүлэн үйлдэгч бүгдээр хэзээ ч бүтээж үйлдэж эс чадсан юм. Тэр учир шалтгаан юунаас хэмээхүл тэдгээр нь өнө эртнээс бодитойд эс бүтсэн Ванчүг тэр нь үр алиныг үйлдэгчид үл бүтэх бөгөөд бодитой үл бүтсэний тул болно гээд "Завашэйраваас" эшлэн үр мөн чанартай аваас шалтгаанаар юуг төрүүлж болох, үр мөн чанаргүй аваас шалтгаанаар юуг төрүүлж болох хэмээсэн тул болой хэмээн Ванчүг тэнгэрийг бүхнийг бүтээгчид үздэг өвөрмөцтний /вашешика/ тогтсон тааллын үзэл онолыг төв үзлийн гүн ухааны гол ном судраас эш татан няцааж байгаа нь тэрээр гүн ухааны үзлийн хувьд төв үзлийг баримталдаг, түүний үзэл баримтлалыг онол практикт хэрэглэж хэрэгжүүлдэг байсныг харуулах юм. Тэрбээр энд юмс үзэгдлийн шалтгаалцлалын холбоонд орших зарчмыг хөндөж гаргасан байна.

Мөн "Ванчүг бээр... бүтсэн, бүтээгүй үр хоёуланг төрүүлэн үйлдэгч гэх аваас тэр нь машид үл тохирох бөгөөд мөн чанар нь хэзээд ч үл урван ном ба ахуй үест төрдөг, эвдэрдэг ном хоёр бэлгэ чанарын үүднээс харшлахын тул. Мөнх, мөнх бус хоёр чанарын үүднээс өөр зуураа харшлахын тул болой. Тэр мэт аваас өөрийн мөн чанараар бүтсэн, эс бүтсэн хоёр өөр зуураа харшлах албатай тул. Үлгэрлэвээс гэрэл, харанхуй хоёр нэгэн сууринаа учирч болохгүй ба амьд, үхсэн хоёр нэгэн бодгаль суурь зохилдон хурж үл болох мэт болой"¹⁴ хэмээн дээрх санаагаа улам гүнзгийрүүлэн Ванчүг бүтсэнийг бүтээж чадахгүй, нэгэнт бүтчихсэн тул: эс бүтсэнийг бүтээж бас чадахгүй, ерөөсөө бүтээгүйн тул. Бүтсэн, эс бүтсэнийг бас бүтээж чадахгүй, учир нь эсрэг тэсрэг чанар харшлахын тул хэмээн тус тус баталж байна. Энд тэрбээр "өөрийн мөн чанараар бүтэхүйг" үгүйсгэхдээ бие биеэ үгүйсгэсэн эсрэг тэсрэг чанарууд нэгэн орон, цагт нэгэн зэрэг үл орших зүй тогтлыг гэрэл, харанхуй хоёроор үлгэрлэн гаргасан нь Заваа Дамдин гавжийн гүн ухааны үзэл дэх диалектик баримтлал гэж хэлэх үндэстэй юм.

Зохиолын гол хэсэгт Ванчүг ертөнцийг бүтээгч бус болохыг буддын гүн ухааны гол арга зүйн нэг болох "няцаалтаар" үзүүлэхдээ:

1. Эс төрсөн Ванчүгийг үйлдэгч хэмээн өгүүлснийг хорих

¹⁴ Мөн боть 461 дэх талд

2. Ванчүгийг үйлдэгч хэмээн өгүүлэхийг хорих гэсэн 2 үндсэн няцаалтыг гаргасан байна. Үүнд: Ванчүг нь өөрөө шалтгаан, нөхцлөөс төрсний мөн чанараар бусад үрийг төрүүлэн үйлдэх буюу? Тэгвэл өөрөө шалтгаан, нөхцөл, үрийн холбоогоор нөхцөлдөн бүтсэн юм бол түүний урд гарсан шалтгааныг тэр бүтээсэн хэрэг үү хэмээн бататгаж өгч, өөрөө шалтгаан нөхцлөөс эс төрсний мөн чанараар бусад төрүүлэн үйлдэгч хэмээн тооцох уу гэж асуудлыг өөрт нь сөргүүлэн тавьж байна.

Эсвэл өөрөө шалтгаан нөхцлөөс эс төрсөн гэвэл Ванчүг тэр нь хоромхон зуур бусад үрийг төрүүлэн үйлдэж эс чадах бөгөөд учир юу вэ гэвэл өөрөө шалтгаан нөхцлөөс эс төрсөн, хэрэг тусыг үйлдэн чадагч нь хоосон мөн чанар мөний тул болой. Үлгэрлэвээс хүүсэр эмийн хүү тэр нь өөрөө шалтгаан, нөхцөл алинаас ч эс төрсний учраар газар ухах тэргүүтэн үйлийг цаг хэзээд бүтээж үл үйлдэнэ. Тэр мэт эс төрсөн Ванчүг нь үрийг үүсгэн үйлдэх болой хэмээсэн нь хүүсэр эмийн хөвүүн бээр газар ухна хэмээсэн лүгээ адил инээдэм наадмын орон болно гэж Ванчүг бээр эс төрснийг бүтээн үйлдэхийг няцаасан эл хэсэгт тун оновчтойгоор төв үзлийн үгүйсгэх зарчмыг хэрэглэсэн байгаа юм.

...Ванчүг нь өөрөө шалтгаан, нөхцлөөс төрсний мөн чанараар бусад үрийг төрүүлэн үйлдэх болой хэмээвээс өөрийн эрхэт эдэт Ванчүг төрсний мөн чанараар бусад үрийг төрүүлэн үйлдэх цагт тэр мэт Ванчүг өөрийн эрхтэй зай өөрөөс төрсөн тул үрийг төрүүлэн үйлдэх буюу, өөрийн эрхшээсэн зай бусдаас төрсний тул юм уу, хоёулангаас төрсөн тул буюу, хоёул бус нэгнээс тул төрүүлэгч үйлдэгч хэмээн онон тооцох уу?

...Ванчүг өөрийн мөн чанараар төрсөн тул бусад үрийг төрүүлэгч бус бөгөөд өөрөө өөрийн мөн чанартаа шалтгаан, үр хоёрыг хоёулангийн үйлийг үйлдэх нь зохис лугаа харш. Үлгэрлэвэл маш хурц илдний ир ч өөрийгөө огтхон үйлдэх нь ашид үгүй ба сайтар суралцсан мэргэн бүжигчин ч өөрийн мөрөн дээрээ мордоод бүжиглэн үйлдэх нь ашид үгүй тул болой. ... Ванчүг өөрийн мөн чанар ямагтыг өөрийн төрүүлэгч мөн болой хэмээн энэ мэт сэтгэлдээ үзэн үүгээр өгүүлэхийг хүсвээс төрөлхтөн бээр өөрөө өөрийн эцэг хийгээд өөрөө өөрийн хүү гэвэл машид хэтэрсэн болно. Энэ мэт ам авах нь тогтсон таалал бүү хэл ертөнц дахинаа алдаршсан нь үгүй болой. Тэр нь ч “Завашэйрав” –аас шалтгаан, үр дагавар нэгэн чанарт аваас төрүүлэгч, төрөгч нэг болох хэмээсэн болой” гэх буюу эцэстээ шалтгаан, үр хоёр нэгэн зүйл болж хэтэрнэ гэж тус үзлийг тал бүрээс нь хаан үзүүлсэн ажгуу. Ингэж Заваа Дамдин гавж бээр төв үзлийн гүн ухааны бүхнийг бүтээгчийг эс зөвшөөрөх хийгээд үнэхээр эс бүтэхүйн

зарчмыг баримтлагч болох нь тодорхой харагдаж байна. Тэрээр эл зохиолд гадаад тогтсон тааллын үзэл онолтой зөрсөн хэсэг тутамдаа төв үзлийн гол судар номоос эш татан баталгаажуулж байгаа нь түүний буддын гүн ухаанд мэргэшсэн, гүн сэтгэгч байсныг харуулж байна.

Заваа Дамдин гавжийн нэр алдрыг дэлхий дахинаа танил болгон дуурсгасан зохиолыг нэг нь “Нигүүлсэхүй сэтгэлийн дуулал зуун найман шүлэгт болор эрдэнийн эрхи” болно.

Эл зохиол яруу найргийн хэлбэрээр мөрийн тоо үеийг тохируулан, толгой сүүл холбож, адилтгал зүйрлэл чимэглэлүүдийг өргөн хэрэглэж, 108 бадгаар бичигдсэн гүн ухааны зохиол болно.

Эл зохиолоо тэрээр Их хүрээнд Данжуурын эш лүнг сонсож байхдаа 1913 оны хаврын тэргүүн сарын шинийн найманд зохиосон нь:

Нигүүлсэхүйн орон болсон цөв цагийн

Нигүүлсэхүйн рашаанаар үндсийг чийгтүүлэхийг

Нигүүлсэхүйн бурхан адистидлах болтугай

хэмээн их нигүүлсэхүйг магтсан зуун найман бадагт “Болор эрдэнэ эрхи” хэмээгч үүнийг хөлгөний олон буяны садны сэтгэшгүй нигүүлсэхүйн адистаар номын ёсыг өгүүлэхүй самбаа өчүүхэн сайнтай тойн дүрст зальхай Лувсандаян бээр арвантавдугаар жарны дөчиндолдугаар жилийн рид хувилгааны сарын шинийн үед Их хүрээнд Данжуур эрдэнийн лүнг сонсож ахуй суудалд хотол атгагийн зурагт ургасан ёс ямарчлан шинийн наймны өдрөө цаасанд бичин байгуулсан үүгээр ч амьтан даяар их хөлгөний номд агуу их сүслэн бишрэхүйгээр хэзээ ч ханалгүй төгс эдлэх болтугай. Сайн буян арвидах болтугай. Сарвамангалам”¹⁵ гэсэн төгсгөлийн үгнээс тодорхой буй.

Тус зохиол нь Бурханы шашины их хөлгөний ёсны гүн ухааны гол үзэл онол болох төв үзлийн гүн ухааны номлолын зүрхэн шим болсон бүтээл юм. Буддын гүн ухаанд арга хэмээх асрал нигүүлсэхүй сэтгэл, билиг хэмээх хоосон чанарыг оносон билиг ухаан хоёрыг эрхэм зүйлээ гэж үзэл онолынхоо гол үндэс болгосон байдаг. Их хөлгөний гүн ухаанд үзэхдээ бодь сэтгэлийг үүсгэх хэд хэдэн арга буй. Тэдгээрийн нэг нь шалтгаан үрийн долоон увидис болно. Эл долоон увидис нь дараах байдлаар томъёологдоно. Үүнд. Эх мэт үзэх сэтгэлээс ачийг санах сэтгэл, ачийг санах сэтгэлээс хариулахуй сэтгэл, ачийг хариулахуй сэтгэлээс асрахуй сэтгэл, асрахуй сэтгэл түүнээс нигүүлсэхүй сэтгэл,

¹⁵ sNying rje chen po la pstod pa'l tshig bcad brgya rtsa brgyad ba rin chen shel phring zhes bya ba bzhuqs so, Модон барын судар, 18 дээд-доод галд

нигүүлсэхүй сэтгэл түүнээс үзэмж сэтгэл, эцэст нь тэдгээрийн үндсэн дээр бодь сэтгэл үүсдэг гэдэг. Эдгээрийн дотроос нигүүлсэхүй сэтгэл нь их хөлгөний зам мөрийн эхнээс эцэст хүртэл хамгийн гол хөдөлгөгч хүч-арга болдог тул түүнийг их хөлгөний эхэн, дунд, адагт тус эрдэм хамгийн ихтэй гэж үздэг. Их хөлгөний эхэнд гэдэг нь түүнийг төрөх эх үндэс болдог, дунд гэдэг нь түүний зам мөрд ороод арга билгийн ухааныг сурах үед өсгөж арвижуулах гол хөрөнгө болдог, эцэст гэдэг нь хоосон чанарыг онож мэдсэн бурхан, хутагтанд хүрсн хойно эх болсон 6 зүйл хамаг амьтанд тусыг хүргэх эх шалтгаан болдог гэж тус тус үздэг юм. Арга, билгийг хослон бүтээж гэгээрлийн дээдэд хүрдэг буддын сургаал номполын салшгүй эрхэм зүйл асрал нигүүлсэхүйн тухай Заваа Дамдин гавж бичихдээ:

Их төрөлхтний замын үүдэн
Их хөлгөний мутрын тамга
Их бодийн байдсан хөрөнгө
Их нигүүлсэхүйд бишрэн мөргөмүү
Хамаг ялгуугсадыг үүсгэгч эх
Хамаг бодьсадын хайрт эд
Хамаг амьтан үл таних амраг
Их нигүүлсэхүй намайг ивээгтүн
Альмад ганцад мөргөж үйлдвээс
Хамаг ялгуусан шавь нар сэлтэд
Мөргөл тахилыг үйлдсэнд тооцогдох
Их нигүүлсэхүйг магтмуй би

хэмээн нэг талаас хүний ёс суртахуун нөгөө талаас зан байдлын нэг гол шинж, шалгуур болсон асран нигүүлсэхүй сэтгэлийг тодорхойлоод

Их нигүүлсэхүйг бясалгасны
Хүчин сайтар төрөхүй цагт
Илт туулсан бурхан болох тул
Та бурханыг үйлдэгч ном амуй
Бурханы шашин мөн бүгд нь
Нигүүлсэхүйгээр сайтар ялгарах ба
Үл хөнөөхийн мөн чанарт орших тул
Та дээдийн номыг үйлдэгч ном амуй
Бурхан багшийн шавь нарыг
Нигүүлсэхүйн авир ёсыг сахиулахуй хуулийг
Хуврагын дөрвөн номсор агуулах тул

Та ану хуврагийг үйлдэгч ном амуй
гэж түүний үр дагаврыг гаргасан байгаа юм. Бас эл зохиолоор Зава Дамдин
гавжийн нийгэм ёс суртахууны үзэл илэрч байна гэж хэлэх үндэстэй. Тухайлбал:

Бид өөрийн хохь бүхнийг
Бусдын толгойд юүлэх буюу хуваах ба
Бусдад хотол чуулган буй бүхнийг
Өөрийн болтугай хэмээн хүсмуй

Та өөрийн хамаарах амгалан баялаг бүхнийг

Бусдад өгөх буюу хуваах ба

Бусдад зовлон буй бүхнийг

Миний болтугай хэмээн бясалгадаг

Бусдууд ялгуугсдад бишрэвч

Амьтнуудад уригнан үйлддэг

Та ану хэрцгий ардад ч

Бурхан лугаа адил бишрэн тахиж үйлддэг

гэж нигүүлсэхүй сэтгэл хийгээд нигүүлсэхүй бус сэтгэлийн чанар хоёрыг
хооронд нь харьцуулан шүүмжилж гаргасан нь угтаа бол хүний сэтгэлийн сайн,
муу төлөв байдлуудыг шүүж эсэргэцүүлэн хэлсэн хэрэг буюу.

...Зовлонгоос ихэд айвч

Хилэнцээс үл айгч бидний ёс

Зовлонгоос ч хилэнцээс ч

Буман хувь айдаг нь таны төрх

гэж нигүүлсэхүйг нийтэд нь дүгнэн гаргажээ. Эл бүхий нигүүлсэхүй сэтгэлийг
илэрхийлж байгаа агуулгаас үзэхэд тэрээр нигүүлсэхүй сэтгэлийн тухай
асуудлыг боловсруулж тавьсан буддын үндсэн зохиолуудыг эх сурвалжаа
болгосон нь илт байгаа юм.

Тэрчлэн “Төв үзлийн шастар Нягтад тээрэмдэгчийн тайлбар, Ухаарахуй
ёст алтан хүрдэн” зохиолдоо төв үзлийн “үнэхээр эс бүтэхүйн” зарчмыг логик
үндэслэгээтэй рациональ сэтгэхүйгээр хаан хорих-няцаах аргазүйгээр гаргаж
илэрхийлсэн буй. Ер нь монголын гүн ухааны сэтгэлгээний хөгжилд эртний
энэтхэгийн ... гүн ухааны категориудыг илэрхийлж байгаа нэр томъёог нь хүртэл
авч хэрэглэсэн зүйл байх ба харин түүнийг монгол сэтгэгчид цааш бодож
боловсруулж, .. хөгжүүлж байсныг”¹⁶ Заваа Дамдин гавжийн эл бүтээлээс

¹⁶ Ч.Жүгдэр, З.Агванбалдангийн гүн ухааны үзэл, УБ., 1978, 110 дахь талд

тодорхой харж болно. Тэрээр буддын дотоод ухааны тулгуур ач холбогдол бүхий хэд хэдэн сурвалж шастарт, түүний дотор эртний Энэтхэгт хөгжин боловсорч асан Ньяя философийн “Үг, утга арванзургаа” гэх “Шалгадаг мэдэл, үлигдэхүүн, сэжиг, хэрэг үлгэр, тогтсон таалал, гишүүн, шинжлэл, нотлон шийдэхүй, тэмцэл, өгүүлэхүй, шүүн эсэргүүцэхүй, засдаг учир шалтгаан, үгсийг ороохуй, хэтрүүлэхүй, гэсгээхийн орон” гэсэн үндсэн ойлголт, категориудыг буддын төв үзлийн үнэхээр эс бүтэхүйн зарчмын үндсэн дээр хорин үйлдэж, угтаа тэдгээр нэг бүрийн жинхэнэ утга холбогдлыг шинжлэн тодруулж боловсруулсан гарамгай гүн ухаантан Нагаржунагийн “Нягтад тээрэмдэгч” шастарт утга тайлал хийж, бас ч өөрийн санаа, жишээ үлгэрээр баяжуулан тодруулж тайлбарласан нь эл зохиолд хийсэн ховорхон тайлбарын нэгэнд зүй ёсоор орж байна. Төв үзлийн тус шастарын утга тайллыг шалгадаг ухааны дасгал хаях буюу харилцан яриа, маргаан мэтгэлцээний хэлбэрээр, учир шалтгааны ухааны гаргалгааны хувилбаруудаар, үгүйсгэл гаргалгаагаар дагнан илэрхийлсэн нь тус шастарын бичлэгийн онцлог болно.

Үнэхээр бүтсэн гэх ертөнцийг бүтээгч гагц эзнийг хүлээн зөвшөөрөхүйдээ баталгаа болгож хэрэглэсэн эртний энэтхэгийн гүн ухааны эдгээр арванзургаан категорийг Заваа гавж тус бүрд нь хааж, угтаа тэдгээр нэг бүрийн “үнэхээр эс бүтсэн” болохыг тууштай гарган харуулжээ. Ингэхдээ тэрбээр асуудалд тууштай диалектикч байр сууринаас хандаж, мөнхдүүлэх хийгээд тасархайдуулах “хоёр халил хязгаарт унахаас сэргийлж чадсанд түүний гаргалгааны хатуу чанд логик оршино гэж үзнэ. Ерөөс ч туйлчлах үзлийн баримтлахыг цээрлэж, эцэстээ вумынхан ч чаралбын гэх гадаад тогтсон тааллынх ч аль аль нь үнэхээр эс бүтсэн бөгөөд гагцхүү юмсын дотоод, түгээмэл шүтэн барилдлага л мэдрэхүйн ертөнцийг үнэхээр бүтчихсэн мэт хуурамч дүр төрхөөр үзүүлдэг болой гэж баталсан юм. Тиймээс ч тэрхүү шүтэн барилдлагыг л онож ухаарах нь чухал гээд, түүний цаана зөвхөн хоосон чанар буй хэмээчүхүй. Өөрөөр хэлэхүл, тэрбээр юмсыг үнэхээр бүтсэн, туйлын биеэ даасан, цул зүйл гэх буддын бус гүн ухааны урсгал чиглэлүүдийн үзэл сургаалыг хоосон чанарын онолын үүднээс үгүйсгэл гаргалгаагаар дамжуулан няцааж үйлдсэн л хэрэг болно. Энд хэрэглэн бүхүй няцаах арга зүй нь гагц учир шалтгааны ухаанд ч хамаатай бус, бас төв үзлийн гүн ухааны гол үндсэн арга зүй мөн гэж үзнэ. Төв үзлийн гүн ухааны эл няцаан хаах арга зүй нь хоосон чанарыг онон ухаарах, илэрхийлэх гол оньс болгоно. Эл бүхий хорих, няцаах арга нь энгийн механик үгүйсгэл огт

бус, харин ч логик, рациональ сэтгэхүйд тулгуурлан, гүн диалектик агуулга бүхий болой.

Ашигласан ном зохиол

1. dBu ma'l spyi don gol mchan 'grel zab don rab gsal sgrom me Сүмбүм Nga боть .
2. dBu ma'l bstan bcos zhib mo rnam thag gi 'grel pa rigs thsul gser 'khor lo, Сүмбүм, мөн боть.
3. dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l rnam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, мөн боть.
4. sNying rje chen po la pstod pa'l tshigs bcad bgya rtsa brgyad pa rin chen shel pgreng, Сүмбүм, Ка боть.
5. dBang phyug byed pa po nyid sel ba dang phyab 'jug byed pa po gcig nyid sel bar byed pa zhes bya ba'
6. Frederick William Thomas. Notes from the Tanjur: Isvarakarttrvanirakti- visnorekakartrvanirakarana. 1903. JRAS. Ф.Щербатской. Abuddhist philosopher on Monotheism. Tr.By Harish C.Gupta Indian Studies Past and Present. Repr. N.C.Gupta, ed., Papers of Theodore Scherbatsky, Calcuta, 1969. Pp., 10-16: George Chemparathy. Visnorekakartrvanirakarana . 1968 in "Two Early Buddhist Refutations of the Existence of Isvara as the Creator of the universe" Frauwallner Festschrift.
7. dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l rnam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, Nga боть.
8. Г.Лувсанцэрэн. Нагаржунагийн философийн үзэл, УБ., 1981.
9. Монгол Данжуур, 221 дүгээр боть.
10. Халуун оронд ургадаг нэг наст ургамлын нэр. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
11. dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa'l rnam bshad ngan nad brgya sel ba'l sman gcig, Сүмбүм, Nga боть.
12. sNying rje chen po la pstod pa'l tshig bcad brgya rtsa brgyad ba rin chen shel phring zhes bya ba bzhuqs so, Модон барын судар.
13. Ч.Жүгдэр, З.Агванбалдангийн гүн ухааны үзэл, УБ., 1978.

**MIDDLE WAY ISSUES OF ZAVAA DAMDIN
KABJU ON SOME SASTRAS**

Zavaa Damdin made a comment on “**dBang phyug sogs byed pa bo gcig nyid sel bar byed pa’l rnam bshad**” saying that “Isvara and his disciple could suppress the wrong idea of creating the universe... with sober wisdom”. If we say all creator, can be say all that have been produced, or all those that have not created; if we say not created; can we name sand gunjid oil, hair on the tortoise; how can we create all of that. Created and creating of those that have not been produced, could never exist side by side, according to him, there is no powerful heaven can create everything that is wished.

Thus Zavaa Damdin kabju is a great thinker and philosopher who has citid from the sutras of Middle-way, a proof on the middle path-Madhyamika on points of disagreement of all creator and on the principles of not-creator.